БАТЛАВ

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАН-ОД

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨРӨЛЖСӨН ХАБЫГ БАЙГУУЛАХ ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ /6 БҮС ТУС БҮРТ/ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

| № | Захиалагч байгууллага | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам |
|---|---|---|
| 1 | Эрх зүйн үндэслэл | Эрх зүйн орчин:<br>1. 2012 онд батлагдсан Инновацийн тухай хуулийн 16 дугаар зүйлд Инновацийн дэд бүтцийн байгууллагуудыг тусгаж өгснөөр Мэдээллийн технологийн хаб буюу хамтын оффис байгуулах эрх зүйн үндэслэл бүрдсэн.<br>16.4. Хамтын оффис нь хоорондоо хамааралгүй хэд хэдэн хувь хүн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах таатай орчныг хэлнэ.<br>2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:<br>2.4.9.Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацын татваргүй бүсийг Хамтын оффист түшиглэн байгуулна.<br>3. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:<br>2.1.2.3. Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, инновацад суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт /гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөр/-ийн орчныг сайжруулна.<br>2.1.3.15. Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлнэ.<br>4. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал:<br>Бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилт: Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилгод: Бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ зорилтын:<br>3.1.5.Шинэ Хархорум хотод "Орхоны хөндий" өндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулна. |
| 2 | Зорилго | Монгол улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих экосистемийг бий болгох зорилгоор бүс, орон нутгийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан өндөр технологи, инновац, судалгаа бизнес хөгжлийн төв (R&BD)-ийн үйл ажиллагаа бүхий **Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис** байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх. |
| 3 | Ажил гүйцэтгэх хугацаа | Гэрээ байгуулсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд тус ажлыг хийж гүйцэтгэнэ. |

<table>
<tr><td>4</td><td>Хүлээгдэж буй үр дүн</td><td colspan="4">Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисыг 6 бүс тус бүрт байгуулахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн хамт</td></tr>
<tr><td>5</td><td>Хүлээж авах материал</td><td colspan="4">1. Олон улсын (2-3 орон) болон дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих экосистемийн дэд бүтцийн суурь болох мэдээллийн технологийн төрөлжсөн хабуудын үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа;<br>2. Инновацийн тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журам, өндөр технологи, гарааны бизнесийн эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгаа;<br>3. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын байр, шаардлагатай лаборатор зэрэг төслөөр тодорхойлогдсон холбогдох байр байгууламж, техник тоног төхөөрөмжийн хүчин чадал, холбогдох зардлын судалгааны тайлан<br>4. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын үйл ажиллагаанд тавигдах шаардлага/олон улсын стандартад нийцсэн байдлаар/<br>5. Эдийн засгийн үр ашгийн тооцоолол<br>6. Холбогдох зардлын талаарх мэдээлэл, судалгаа<br>7. 6 бүс тус бүрт баригдах барилга, байгууламжийн ажлын зураг төсөл/хавсралт 2-т заасан шаардлагын дагуу боловсруулах/<br>8. Баримт бичгийн 2 болон 3 дугаар хэсэгт заасан бусад холбогдох материал<br>9.</td></tr>
<tr><td rowspan="4">6</td><td rowspan="4">Төсөл хэрэгжүүлэх баг</td><td>1.Багийн бүрэлдэхүүн</td><td>Тоо</td><td>Боловсрол, мэргэжлийн ур чадвар</td><td>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</td></tr>
<tr><td>2.Багийн ахлагч</td><td>1</td><td>Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (061) эсхүл бизнесийн удирдлага (0413)</td><td>5 болон түүнээс дээш</td></tr>
<tr><td>3.Мэдээллийн технологийн төрөлжсөн ХАБ-ын ТЭЗҮ хариуцсан гишүүн</td><td>2</td><td>Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (061) эсхүл бизнесийн удирдлага (0413), судлаач</td><td>3 болон түүнээс дээш</td></tr>
<tr><td>4.Мэдээллийн технологийн төрөлжсөн ХАБ-ын зураг төсөл хариуцсан гишүүн</td><td>1</td><td>Барилгын инженер, Архитектор ба барилга угсралт, инженерчлэл болон</td><td>3 болон түүнээс дээш</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | барилгын бусад | |
| | | 5.Холбоо дохиололын инженер | 1 | Холбоо дохиололын инженер | 3 болон түүнээс дээш |
| | | 6.Цахилгааны инженер | 1 | Цахилгааны инженер | 3 болон түүнээс дээш |
| | | 7.Ус хангамж, ариутгах татуургын инженер | 1 | Ус хангамж, ариутгах татуургын инженер | 3 болон түүнээс дээш |
| | | 8.Төсөвчин | 1 | Мэргэшсэн төсөвчин болон түүнээс дээш | 5 болон түүнээс дээш |
| 7 | Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага | Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилд тухайн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй үйлчилгээг доод тал нь нэг удаа үзүүлсэн туршлагатай байх.<br>Ижил төстэй үйлчилгээ гэдэгт бүхий л төрлийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулсан туршлагыг тооцно. | | | |
| 8 | Тайлан хүлээлгэж өгөх | Тайланг дараах байдлаар хүлээлгэн өгнө:<br>1. Урьдчилсан тайлан: Гэрээ байгуулсан өдрөөс 6 долоо хоногийн дотор<br>2. Хяналтын тайлан: Захиалагчаас өгсөн саналыг тусгасан байдлаар санал өгснөөс хойш 2 долоо хоногийн дотор<br>3. Эцсийн тайлан: Энэ хэсгийн 8 дугаар зүйлд холбогдох бүх эцсийн тайлан, материалыг гэрээ байгуулснаас хойш 3 сарын хугацаанд.<br>Гүйцэтгэгч 2, 3 дахь хэсэгт заасан ажлыг бүрэн гүйцэтгэж, тайланг цахим болон цаасан хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээр ажил дуусгавар болно. | | | |

## 2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн хабын техник, эдийн засгийн үндэслэл

| № | Гүйцэтгэх ажил | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|---|
| 1 | Өнөөгийн байдлын судалгаа | 1. 2-3 улсын болон дотоодын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих экосистемийн дэд бүтцийн суурь болох мэдээллийн технологийн төрөлжсөн хабуудын үйл ажиллагааны өнөөгийн байдлын судалгаа;<br>2. Өндөр технологи, инновац, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгаа;<br>3. Өндөр технологи, инновац, судалгаа бизнес хөгжлийн төв (R&BD)-ийн үйл ажиллагаа бүхий хаб/хамтын оффисын үйл ажиллагаанд тавигдах стандарт.<br>4. Төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар тус мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын үйл ажиллагааг цаашид хэрэгжүүлэх боломжийн талаарх санал, зөвлөмж |
| 2 | Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффист | 1. Өндөр технологи, инновац, судалгаа бизнес хөгжлийн төв (R&BD)-ийн үйл ажиллагаа бүхий хаб/хамтын оффисын үйл ажиллагаанд тавигдах шаардлага |

| | | |
|---|---|---|
| | явуулах үйл ажиллагааны талаарх судалгаа, төсөөлөл | 2. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын явуулах үйл ажиллагааны төрөл, чиглэл<br>3. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффист байрлаж ажиллах гарааны бизнес, стартапын багтаамж, эргэлт, хүний нөөц, хүчин чадлын тооцоо судалгаа<br>4. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөөлөл 3 болон 5 жилээр<br>5. Үйл ажиллагаанаас олох орлого, зардлын талаарх төсөөлөл |
| 3 | Холбогдох хууль эрхзүйн орчны судалгаа | Инновацийн тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журам, өндөр технологи, гарааны бизнесийн эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгаа; |
| 4 | Шаардагдах байр байгууламж, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл | 1. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффист байх шаардлагатай лаборатори, судалгаа бизнес хөгжлийн (R&BD) төв, анги танхим, уулзалтын өрөө болон бусад холбогдох зайлшгүй шаардагдах хэсгүүдийн жагсаалт<br>2. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын байр, байгууламжид тавигдах шаардлага<br>3. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффист шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хүчин чадал |
| 5 | Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын байршил, байрыг тодорхойлох | 1. 6 бүс тус бүрт байгуулагдах мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисын байршил<br>2. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисыг байгуулахдаа өнөөгийн байдлаар тухайн бүсд байгаа барилга байгууламжид байршуулах (А хувилбар), эсхүл шинээр байр байгууламж, холбогдох эдэлбэр газартай барьж байгуулах (Б хувилбар) талаарх мэдээлэл/6 байршил тус бүрд<br>3. Шаардлагатай тохиолдолд эдэлбэр газартай байхаар бол газрын хэмжээ, солбилцол, газрын зөвшөөрөл авахтай холбоотой үйл ажиллагаа, холбогдох материалын жагсаалт |
| 6 | Эдийн засгийн үр ашгийн тооцоо | 1. Тус Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффисыг 6 бүс тус бүрт байгуулснаар нийгэм, эдийн засагт гарах үр ашгийн тооцоог дараах хувилбараар:<br>1.1. Өнөөгийн байдлаар тухайн бүсд байгаа барилга байгууламжид байршуулж ажилласан тохиолдолд<br>1.2. Шинээр байр байгууламж, холбогдох эдэлбэр газартай байгуулах тохиолдолд |
| 7 | Холбогдох зардлын талаарх мэдээлэл, судалгаа | 1. Төслийг хэрэгжүүлэхэд гарах холбогдох зардлын харьцуулсан судалгаа:<br>1.1. Шинээр байр байгууламж, холбогдох эдэлбэр газар шаардлагатай тохиолдолд холбогдох зардлын судалгаа<br>1.2. Өнөөгийн байдлаар тухайн бүсд байгаа барилга байгууламжид байршуулж ажилласан тохиолдолд гарах холбогдох зардлын судалгаа |

| | | |
|---|---|---|
| | | 1.3. Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх тохиолдолд гарах зардлын судалгаа<br>2. Хүний нөөц, цаашид үйл ажиллагаа явуулах зардлыг мөн хувилбараар тооцох<br>3. Үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хангамж, ширээ сандал зэргийн санхүүжилтийн хэмжээ нийт зардлын 35 хувиас хэтрэхгүй байх. |

**4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн хабын зураг төсөл /6 бүс тус бүрт/**

| | | |
|---|---|---|
| 1 | Байршил сонгох | 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн хабын зураг төслийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасны дагуу 6 бүс тус бүрт байхаар төлөвлөнө.<br>• Хангайн бүс<br>• Баруун бүс;<br>• Хойд бүс<br>• Төвийн бүс<br>• Зүүн бүс<br>• Говийн бүс<br>2. Төвүүд нь тухайн бүсийн аль байршил буюу аймаг, сумд байрших талаарх саналыг 2 дугаар хэсэгт тусгасан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн хабын техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хувилбарт /шинээр барилга байгууламж, эдэлбэр газартай барих(А хувилбар), эсхүл өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламж дотор (Б хувилбар)/ байдлаар боловсруулна. |
| 2 | Эдэлбэр газрын хэмжээ | Төслөөр |
| 3 | Зориулалт, хүчин чадал | Төслөөр |
| 4 | Төсөл гүйцэтгэх хугацаа | Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 5 | Барилгын үндсэн бүтээц, материал | Төслөөр |
| 6 | Зураг төслийн шат | 1. Шинээр барилга байгууламж барих /А хувилбар/ тохиолдолд тухайн бүс нутгийн хүн амын нягтаршил, салбарын хүний нөөцийн онцлогт тулгуурлан барилга төлөвлөлтийг хийхдээ, эдгээр шинээр баригдах төвүүд нь тус бүрдээ судалгаа хөгжүүлэлтэд зориулсан газартай (1 га болон түүнээс дээш) болон оффис, заалны барилгын суурийн талбай нь 1000 метр квадрат ба түүнээс дээш талбай бүхий, цэвэр бохир ус, дулааны цахилгааны орчин үеийн шийдэлтэй байх шаардлагатай.<br>2. Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламж дотор барих /Б хувилбар/ тохиолдолд тухайн байгууламжийн хүчин чадал олон улсын стандартад нийцэх боломжтой эсэх, мөн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрөлжсөн хабын үйл ажиллагааг явуулахтай холбогдуулан авах шаардлагатай зөвшөөрлийг тооцох |

| | | |
|---|---|---|
| 7 | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | Техникийн нөхцөл шаардлагатай бол ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах. |
| 8 | Зураг төслийн иж бүрдэл | 1. Баримт бичгийн иж бүрдэл:<br>1.1. Инженер геологийн дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;<br>1.2. Байр зүйн дэвсгэр зураг /газар доорх болон дээрх шугам сүлжээний тодруулгын хамт/;<br>1.3. Мэргэжлийн хяналт болон Онцгой байдлын дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;<br>1.4. Магадлалын дүгнэлт /хавсралтын хамт/;<br>2. Ажлын зургийн иж бүрдэл:<br>2.1. Иж бүрэн ажлын зураг;<br>2.2. Гадна инженерийн шугам сүлжээ /шаардлагатай тохиолдолд/;<br>2.3. Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны программаар/;<br>3. Зураг төсөлд тавигдах шаардлага:<br>3.1. Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;<br>3.2. Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:<br>3.2.1. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх;<br>3.2.2. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх; |
| 9 | Төсөл боловсруулах үе шат | Ажлын зураг төсөв:<br>1. ХАБ-ын үйл ажиллагааны чиглэлийн үндэслэл болон төлөвлөлт (Олон нийтийн интернетийн нэвтрэх цэг /PIAP/, Инкубатор/Хамтран ажиллах орон зай, сургалт болон тусгай салбарын орон зай байх эсэх)<br>2. Эх загвар зураг боловсруулж, батлуулах; /шаардлагатай тохиолдолд/<br>3. Ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах; |
| 10 | Төсөл боловсруулах байгууллага | Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд |
| 11 | Онцгой нөхцөл | 1. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулна. |

| | | |
|---|---|---|
| | | 2. Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төсвийг боловсруулах; |
| 12 | Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага | Ерөнхий төлөвлөгөө /А хувилбар/:<br>1. Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах;<br>2. Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу төлөвлөх<br>3. Ерөнхий төлөвлөгөөний элементийг тухайн орчинтой уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байхаар төлөвлөх; /гадна гэрэлтүүлэг, мод, зүг чиг/<br>4. Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр төлөвлөх ногоон байгууламжийг төлөвлөлтийн бүсээс гадна нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулан төлөвлөх боломжийг судлан зурагт тусгах; |